

**ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙ**

№	Төслийн нэр	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн нэр	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгагдсан зорилго, зорилт	Төслийн зорилго, зорилт
1	Төмрийн баяжмалыг хорголжлох үйлдвэр	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан бодлогын үндсэн 4 чиглэлийн хүрээнд дараах 14 мега төслийг хэрэгжүүлэхээр төлөвлөгөөний 11-т заасны дагуу Гангийн цогцолборыг ашиглалтад оруулна.	3.3.1.5.Түүхий эд, бүтээгдэхүүнийг анхан шатнаас гүн боловсруулах Кокс-химийн цогцолбор, Нүүрс-химийн цогцолбор, Зэс боловсруулах цогцолбор, Ган үйлдвэрлэлийн цогцолбор, Жоншны хүдэр боловсруулах цогцолбор, Барилгын материал үйлдвэрлэлийн цогцолбор зэрэг хүнд үйлдвэрүүдийг ашиглалтад оруулж, нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүн боловсруулна.	“Бор-Өндөр” УБҮ-ээс нойтон соронзон аргаар баяжуулсан төмрийн хүдрийн баяжмалыг хорголжлон нэмүү өртөг шингээж, дотоодод байгуулагдах металлургийн үйлдвэрийг жилд 200,0 мян.тн хорголжин үйлдвэрлэж чанартай түүхий эдээр хангах зорилготой.
2	Жонш баяжуулах цогцолбор	"Эрдэнэс Монгол" ХХК-ийн 2024-2028 оны дунд хугацааны стратеги төлөвлөгөөний Нэгдлийн дунд хугацаанд хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрүүдэд Үйлдвэрлэл технологийн парк болон бусад боловсруулах үйлдвэрүүдийг барьж байгуулна.	"Жонш боловсруулах цогцолбор Бор-Өндөр ҮТГ"-ийн хүрээнд: Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын нутагт жонш баяжуулах, боловсруулах, химийн үйлдвэрлэл, экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн чиглэлээр "Бор-Өндөр" үйлдвэрлэл, технологийн паркийг байгуулж, жоншны 97 хувийн баяжмал, фторт устөрөгч, фторт хөнгөн цагаан, фторт бүтээгдэхүүн үйлдвэрлэхээр төлөвлөсөн.	Хайлуур жоншны боловсруулалтын түвшин нэмэгдүүлэн нэмүү өртөг шингэсэн өндөр технологийн зах зээлд өрсөлдөх чадвартай шинэ төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж химийн үйлдвэрлэл хөгжүүлэх бололцоог нээнэ. Ингэснээр экспортын бүтээгдэхүүний нэр төрөл нэмэгдэнэ.

## ПЛАН

### Төслийн гүйцэтгэл, явц

- Тус үйлдвэрлэх технологи туршилт, шинжилгээний ажил нь судалгааны үр дүнгээр баталгаажсан.

- Үйлдвэр баригдах 27 га газрыг гэрчилгээжүүлэн авсан.

- Хорголжин үйлдвэрлэх үйлдвэрийн ТЭЗҮ батлагдсан.

- Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийгдэж, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийгдэж байна.

- Үйлдвэр байгуулахад шаардагдах дэд бүтцийн тооцоолол хийсэн.

- "Хорголжингийн үйлдвэр барих 1-р ээлж"-ийн тендер шалгаруулалт амжилтгүй болсон.

- Хайлуурын жоншны баяжмалаас хайлуурын хүчил гарган авах ТЭЗҮ урьдчилсан суурь судалгааны ажил хийгдэж байна.

- Жоншны баяжуулах үйлдвэрийн ТЭЗҮ-г “Эрдэнэс Монгол ҮТП” ХХК-иар ажил гүйцэтгэх гэрээний дагуу боловсруулагдаж байна.